

АМГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн  
2014 оны 08 дугаар сарын 27-ны  
өдрийн 16:00 дугаар тушаалын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОН АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН  
ТАЛБАЙД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ БАРИМТ БИЧИГ

Улаанбаатар хот  
2014 он

## ҮНЭЛГЭЭНИЙ БАРИМТ БИЧИГ

- 1. Ерөнхий зүйл**
- 1.1. Тухайн талбайн босго үнийг баталгаажуулж тооцоо нийлсэн эсвэл босго үнийн 30 болон түүнээс дээш хувийг тусгай дансанд байршуулж баримтаа ирүүлсэн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох эрх нээгдэнэ.
  - 1.2. Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн саналд энэхүү үнэлгээний баримт бичигт заасны дагуу үнэлгээ хийн хамгийн өндөр оноо авсан аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулна.
  - 1.3. Оролцогч нь үнэлгээний баримт бичигт заасны дагуу саналаа ирүүлнэ.
  - 1.4. Өмнөх тусгай зөвшөөрөл эзэмшигч босго үнэ баталгаажуулаад сонгон шалгаруулалтад оролцоогүй тохиолдолд нөхөн төлбөрийг олгохгүй
  - 1.5. Сонгон шалгаруулалт зарласан талбайд 2 ба түүнээс дээш оролцогч санал ирүүлснээр сонгон шалгаруулалт хүчинтэйд тооцогдоно.
  - 1.6. Сонгон шалгаруулалт хүчингүйд тооцогдсон талбайд дахин сонгон шалгаруулалт зарлана.
  - 1.7. Сонгон шалгаруулалтын комисс болон оролцогч нь тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд оролцох явцад холбогдох хууль, журамд заасан ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөнө.
  - 1.8. Сонгон шалгаруулалтын комиссын гишүүд, гишүүнээр ажиллаж байгаа төрийн албан хаагч болон сонгон шалгаруулалтад оролцогч бусад этгээд нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чандлан сахих бөгөөд сонгон шалгаруулалтад оролцогчид эдгээр хуулийг зөрчсөн болон Эрүүгийн хуульд заасан авлига, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.
- 2. Үнэлгээний баримт бичгийг тайлбарлах, засварлах**
- 2.1. Оролцогч нь үнэлгээний баримт бичиг, маягтын талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ урилгад заасан хаягаар саналыг нээх өдрөөс (Саналын урилгын 5 дугаар зүйл) ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө бичгээр ирүүлнэ.

- 2.2. Сонгон шалгаруулалтын үнэлгээний явцад гомдол маргааныг хэлэлцэхээс бусад аль ч шалтгаанаар комисс болон сонгон шалгаруулалтанд оролцогчийн хооронд уулзалт ярилцлага явуулж болохгүй.
- 3. Санал бэлтгэх**
- 3.1. Үнэлгээний баримт бичгийг бүрэн судалж үзсэний үндсэн дээр оролцогч нь саналаа бэлтгэнэ.
- 3.2. Оролцогчийн санал дараах шаардлагыг хангаагүй бол саналыг үнэлэхгүй байх үндэслэл болно.
- А. Оролцогч ААН-ийн саналд хавсаргах баримт бичгийн бүрдэл дутуу  
Б. Оролцогч ААН-ийн санал түүнд хавсарган баримт бичиг, мэдээ мэдээлэл нь зөрүүтэй, илт худал эсвэл хуурамч баримт бичиг хавсаргасан  
В. Эрх бүхий этгээд баталгаажуулаагүй, ААН тамга тэмдэг дарагдаагүй бол
- 3.3. Оролцогч нь саналаа бэлтгэхдээ дараах зүйлийг онцлон анхаарна. Үүнд:
- (1) Тухайн талбайд тавигдсан босго үнэ, санал болгосон үнийг төлөх чадвартай байх, түүнийг нотлох банкны баталгааг хавсаргах.
  - (2) Тухайн талбайд геологи хайгуулын ажил явуулах төслийн баримт бичгийг үнэн бодитойгоор мэргэжлийн түвшинд боловсруулсан байна.
  - (3) Геологи хайгуулын үйл ажиллагаа явуулж байсан ажлын туршлагаа тодорхой дурьдах, нотлох
  - (4) Хайгуулын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээллээ тодорхой дурьдах, баталгаажуулах
  - (5) Хайгуулын үйл ажиллагааг явуулах техник тоног төхөөрөмж, ажлын аргачлалын талаар тодорхой дурьдах
- 4. Санал ирүүлэх, хүлээн авах ба нээх**
- 4.1. Сонгон шалгаруулалтын талбайд өмнө нь тусгай зөвшөөрөл эзэмшиж гарсан зардлаа баталгаажуулж тооцоо нийлсэн аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтад босго үнэ төлөхгүйгээр оролцоно.
- 4.2. Бусад аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтын босго үнийн дүнгийн 30 болон түүнээс дээш хувийг тусгай дансанд байршуулснаар сонгон шалгаруулалтад орох эрх нээгдэнэ.

- 4.3. Оролцогч өөрийн саналын аль нэг хуудсанд алдааг залруулах зорилгоор засвар хийсэн бол түүнийг саналд гарын үсэг зурсан этгээд (гарын үсэг зурах эрх бүхий этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн этгээд) гарын үсэг зурж засварыг баталгаажуулна.
- 4.4. Дээрх этгээд саналын хуудас бүрийг дугаарлан үзэглэсэн байна. Итгэмжлэгдсэн этгээдийн хувьд гарын үсэг зурах итгэмжлэлийг саналд хавсаргана.
- 4.5. Нэг хувилбарт саналыг эх хувь болон хуулбар 2 хувийн хамт монгол хэл дээр ирүүлнэ. Саналыг "ЭХ ХУВЬ", эсхүл "ХУУЛБАР ХУВЬ" гэж тэмдэглэнэ. Эх хувь болон хуулбар хувь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтлана.
- 4.6. Саналын эх хувь болон хуулбар хувиудыг тус тусад нь нэг дугтуйд хийж битүүмжлэн үнэлгээний баримт бичигт заасан санал ирүүлэх хаяг болон бусад мэдээлэл болон "СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КОМИССЫН ОРОЛЦООГҮЙГЭЭР НЭЭЖ ҮЛ БОЛНО" гэж дугтуйн дээр бичиж тэмдэглэнэ биечлэн авчирч тэмдэглүүлнэ.
- 4.7. Саналыг үнэлгээний баримт бичигт заасан хаягаар, тогтоосон хугацаанд ирүүлнэ. Хэрэв бүх дугтуйг 4.5 болон 4.6-д заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй, санал нээхээс өмнө задарсан тохиолдолд сонгон шалгаруулалтын комисс хариуцлага хүлээхгүй бөгөөд задарсан саналыг сонгон шалгаруулалтын комисс хүлээн авч үнэлэхгүй. Хугацаа хоцорч ирсэн саналыг хүлээн авахгүй.
- 4.8. Санал ирүүлэх эцсийн хугацаа дуусмагц сонгон шалгаруулалтын комисс санал авах ажиллагааг хааж тэмдэглэл үйлдэнэ.
- 4.9. Санал нээхэд сонгон шалгаруулалтанд оролцогч аж ахуйн нэгжийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй. Санал нээх үйл явцыг баримтжуулан тэмдэглэл хөтлөнө.
- 4.10. Саналыг нээж сонгон шалгаруулалтын санал түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангасан эсэхийг хянана. Энэхүү хянах ажиллагаа нь сонгон шалгаруулалтанд оролцогч ААН нь эрх бүхий эсэх, ирүүлсэн санал нь хүчин төгөлдөр, бүрэн эсэх,

сонгон шалгаруулалтын үнэлгээний баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилготой.

- 4.11. Комисс нь саналыг нээсний дараа хянах ажиллагааны шатанд сонгон шалгаруулалтын санал түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй бол үнэлгээ хийхээс татгалзан тэмдэглэл үйлдэнэ.

## 5.

### Саналыг үнэлэх

- 5.1. Саналыг нээснээс хойш тусгай зөвшөөрөл олгох хүртэлх хугацаанд сонгон шалгаруулалтын комисст ирүүлсэн саналын талаарх асуудлаар зөвхөн албан бичгээр харилцана. Саналыг үнэлэх, тэдгээрийг харьцуулах ажиллагаанд нөлөөлөхийг завдсан аливаа оролцогч ААН-ийн үйлдэл нь баримтаар нотлогдвол түүний саналыг үнэлэхээс татгалзах үндэслэл болно.
- 5.2 Сонгон шалгаруулалтын босго үнээс дээш үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийг эрэмбэлэн 50-70 хүртэлх оноо өгнө.
- 5.2. Сонгон шалгаруулалтын босго үнийн дүнтэй тэнцүү хэмжээний үнийн саналд 50 оноо, хамгийн өндөр үнийн саналд 70 оноо, хамгийн өндөр үнийн саналаас бага боловч босго үнээс их бусад үнийн саналуудад 50-иас их 70 хүртэлх (50 < 70 ) оноог эрэмбэлэн өгнө.
- 5.4. Сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжийн геологи, хайгуулын ажил гүйцэтгэх төслийн баримт бичигт геологи хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын хэмжээ, ажиллах техник тоног төхөөрөмж, аргачлал, байгаль орчны нөхөн сэргээлтийг төлөвлөсөн байдал, ажлын байр нэмэгдэх хэмжээ, орон нутагтай хэрхэн хамтран ажиллах саналыг үндэслэн 15 хүртэлх оноог өгнө.
- 5.5 Сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжийн геологи хайгуулын ажлын туршлага, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал, хайгуулын ажил хийж гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал зэргийг харгалзан 15 хүртэлх оноог өгнө.

## 6. Комиссын дүгнэлт

Комиссын дүгнэлтэнд дараах зүйлсийг хавсаргана.

1. Хурлын тэмдэглэлүүд
2. Саналын нээлтийн тэмдэглэл

3. Саналд өгсөн үнэлгээ
4. Хянах ажиллагааны явцын тэмдэглэл
5. Сонгон шалгаруулалтын комисс болон сонгон шалгаруулалтанд оролцогчдын хооронд харилцсан албан бичгүүд
6. Оролцогчдын санал болон бусад баримт бичгүүд

**7. Шалгарсан оролцогчийг танилцуулах, тусгай зөвшөөрөл олгох**

- 7.2 Сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ хийж дууссанаас хойш сонгон шалгаруулалтын комисс нь дүгнэлтээ ажлын 3 өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулж, баталгаажуулна.
- 7.3 Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалыг үндэслэн шалгарсан оролцогчдод сонгон шалгаруулалтанд шалгарсан тухай, харин бусад оролцогчдод шалгараагүй тухай үндэслэлийн хамт ажлын 3 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.
- 7.4 Сонгон шалгаруулалтын талбайд өмнө нь тусгай зөвшөөрөл эзэмшиж, гарсан зардлаа баталгаажуулж тооцоо нийлсэн аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтанд оролцоод шалгарч чадаагүй тохиолдолд дээрх ААН-ийн тухайн талбайд гаргасан зардлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагатай тооцоо нийлсэн баримтыг үндэслэн олгоно.
- 7.5 Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч ААН үнийн саналд тусгасан мөнгөн дүнг бүрэн төлсөн тохиолдолд гэрээ байгуулж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгоно.

**8. Төлбөр төлөлт, буцаан олголт**

8.1 Сонгон шалгаруулалт зарлагдсан талбайн босго үнийг Төрийн сан – 900018408 тоот дансанд байршуулан, уг баримтаа эх хувиар нь саналд хавсаргана. Өөр дансанд тушаасан баримтыг тооцохгүй.

8.2 Сонгон шалгаруулалтанд оролцож шалгарсан ААН сонгон шалгаруулалтанд ирүүлсэн үнийн саналын төлөөгүй үлдсэн зөрүүг ажлын 10 өдрийн дотор Төрийн сан – 900018408 тоот дансанд шилжүүлнэ. Зөрүүг шилжүүлээгүй тохиолдолд сонгон шалгаруулалтад удаах оноо авсан ААН-ийг шалгарсанд тооцно.

8.3 Сонгон шалгаруулалтад оролцож шалгараагүй

тохиолдолд тусгай дансанд тушаасан босго үнийг ажлын 10 өдрийн дотор буцаан олгоно.

## 9. Хариуцлага

9.1 Сонгон шалгаруулалтанд оролцож тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай дээр төлөвлөсөн ажлын зардал, хугацаа, гүйцэтгэл болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжилтэнд Төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

9.2 Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай дээр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн зардлыг зарцуулаагүй, ажлын нэр төрлийг бүрэн гүйцэтгээгүй, хугацаанд нь хэрэгжүүлээгүй, үүргээ биелүүлээгүй бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

## 10. Гомдол гаргах

10.1 Оролцогч нь Төрийн захиргааны байгууллагын гаргасан тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол дээд шатны байгууллага болох Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргаж болно.

10.2 Комиссын дүгнэлтийг оролцогч хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргах эрхтэй.

## МАЯГТ 2

**ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОН АШИГТ  
МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТАЛБАЙД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

..... оны ... дугаар сарын ... -ны өдөр

.....  
(аж ахуйн нэгжийн нэр)

.....  
(талбайн нэр)

.....  
(аймаг, нийслэл)

.....  
(сум дүүрэг)

Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	Өгөх оноо	Нийт оноо
<b>ҮНИЙН САНАЛ</b>		
Сонгон шалгаруулалтын үнийн санал: <i>Үнийн сонгон шалгаруулалтын талбайд өгсөн үнийн саналыг эрэмбэлэн үнэлнэ.</i>		70
Сонгон шалгаруулалтын босго үнийн дүнгийн 30 болон түүнээс дээш хувийг тусгай дансанд байршуулснаар сонгон шалгаруулалтад орох эрх нээгдэнэ.		
Сонгон шалгаруулалтын босго үнийн дүнтэй тэнцүү хэмжээний үнийн саналд	50 оноо	
Хамгийн өндөр үнийн саналд	50+20 оноо	
Бусад үнийн саналыг:	0-20 хүртэл	
$20 * (S_{\text{орлоогч}} - S_{\text{босго}})$		
$S_{\text{max}} - S_{\text{босго}}$		
Томъёогоор бодож аравтын орны нарийвчлалтай гаргана.		
Геологи хайгуулын ажил явуулах төслийн баримт бичгийн үнэлгээ <i>Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажлын төслийн баримт бичигт үнэлгээ хийнэ.</i>		15
<ul style="list-style-type: none"> <li>Геологи хайгуулын ажлын зардал, хөрөнгө оруулалтын хэмжээ Зардал, хөрөнгө оруулалтын хамгийн өндөр саналд 5, хамгийн бага саналд 1 оноо өгнө. Бусад саналыг: <math>4 * (XO_{\text{орлоогч}} - XO_{\text{min}})</math> <math>XO_{\text{max}} - XO_{\text{min}}</math></li> </ul>	1-5 оноо	
томъёогоор бодож аравтын орны нарийвчлалтай гаргана.	1-2 оноо	
<ul style="list-style-type: none"> <li>Геологи хайгуулын ажлын арга аргачлал, техник, тоног төхөөрөмж Арга аргачлал оновчтой, шилдэг техник, тоног төхөөрөмжтэй бол - 2 Арга аргачлал дутуу эсхүл үндэслэл муу, уламжлалт техник, тоног төхөөрөмжтэй бол - 1</li> </ul>	1-3 оноо	
<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн төлөвлөлт Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардал, хэрэгжүүлэх хугацааг харгалзан: Бүрэн хангалттай - 3 Хангалттай - 2 Стандарт, дүрэм, журмын шаардлага хангасан - 1</li> </ul>		
<ul style="list-style-type: none"> <li>Ажиллах хүчин Төсөлд ажиллах монгол ажилтнуудын тоо, нийт ажилтнуудад эзлэх хувь 90%-аас дээш монгол ажилтантай бол-2 90 буюу түүнээс доош бол-1</li> </ul>	1-2 оноо	
<ul style="list-style-type: none"> <li>Орон нутагтай хэрхэн хамтран ажиллах талаар Хамтын ажиллагааны нэр төрөл, түүнд зарцуулах зардал</li> </ul>	1-3 оноо	



Ашигт малтмалын 42.1 дэх хэсэгт зааснаас илүү үйл ажиллагаа хэрэгжүүлэх бол-3 Ашигт малтмалын 42.1 дэх хэсэгт заасныг хангаж байгаа бол-1		
Геологи хайгуулын ажлын туршлага <i>Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажлын туршилага зэргийг харгалзин үнэлнэ.</i>		5 оноо
Монголын геологи хайгуул, уул уурхайн салбарт 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан Геологи хайгуул, уул уурхайн салбарт ажилласан туршлагагүй хэднй ч бусад салбарт 10 аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан Шийгээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж /2014 онд үүсгэн байгуулагдсан/	5 оноо 3 оноо 1 оноо	
Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал, тэдгээрийн туршлага, чадвар <i>Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажил гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдлыг харгалзан үнэлнэ.</i>		5 оноо
<ul style="list-style-type: none"> <li>• Тус компанид МУ-ын зөвлөх геологич ажиллах тохиолдолд</li> <li>• Тус компанид мэргэжсэн геологич ажиллах тохиолдолд</li> <li>• Геологич мэргэжлийн үндсэн ажилтантай тохиолдолд</li> <li>• Гэрээгээр геологич ажиллуулах тохиолдолд</li> </ul>	5 оноо 4 оноо 3 оноо 1 оноо	
Техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал <i>Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажил гүйцэтгэх Техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдлыг харгалзан үнэлнэ.</i>		5 оноо
<ul style="list-style-type: none"> <li>• Тус компани геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өрөм, геофизикийн багажтай</li> <li>• Тус компани геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн багажны 50-аас доошгүй хувийг түрээсэлдэг</li> <li>• Тус компани геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн багажаа бүгдийг нь түрээсэлдэг</li> </ul>	5 оноо 3 оноо 1 оноо	
Нийт оноо		100 хүртэл

Үнэлгээг баталгаажуулсан:

Сонгон шалгаруулалтын комиссын дарга /...../

Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга /...../

Сонгон шалгаруулалтын комиссын гишүүд /...../

/...../

/...../

/...../

/...../